



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/408

Улаанбаатар хот

Инженерийн шугам сүлжээ,
тоног төхөөрөмж нийслэлийн
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэх 2,481,114,144.67 (хоёр тэрбум дөрвөн зуун наян нэгэн сая нэг зуун арван дөрвөн мянга нэг зуун дөчин дөрвөн төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн өртөг бүхий хавсралтад заасан инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Энэ захирамжийн 1-д заасан инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ (Ч.Мэндбаяр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110201860



ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГААС НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД
 ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ШИЛЖҮҮЛЭН АВАХ ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ,
 ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Д/д	Байршил	Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, 39А байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2020	26,691,145.00	иргэн Д.Буянжаргал	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
2	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, 38 дугаар байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2019	72,758,000.00	"ЗД констракшн" ХХК	
3	Баянгол дүүргийн 15-р хороо, 30/1 дүгээр байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2007	18,669,916.00	"Монжигүүр" ХХК	
4	Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо, 26А, 26Б, 26В, 26Г байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2022	1,305,718,825.00	"Тайм констракшн" ХХК	
5	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны 215 дугаар байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2021	56,034,000.00	иргэн Г.Батсүхийн захиалгаар "Дарцагт ноёд групп" ХХК	
6	Баянгол дүүргийн 19 дугаар хорооны 66а байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2021	76,319,267.00	иргэн Ц.Оюунжав, "Глобал бридж констракшн" ХХК	
7	Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хорооны Буман-Өлзий хорооллын 754, 755, 756, 757, 759, 760, 761, 762, 763, 764, 765 дугаар байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2015	630,164,662.00	"Ти Си Ди" ХХК	
8	Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны 8В байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2019	160,588,629.67	"Зайсан Стэлс" ХХК	
9	Баянгол дүүргийн 31 дүгээр хороо Баруун Ард Ауушийн 2-р гудамж	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2008	134,169,700.00	иргэн С.Алтангэрэл, Б.Баярханд, Б.Мэнджаргал, н.Цэдэвсүрэн	
Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн дүн				2,481,114,144.67		